

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 02 дугаар
сарын 28-ны өдөр
хот

Дугаар 23

Улаанбаатар

“Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчоос
тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 14.2.13, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5.1.4, 6.2.8 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчоос тайлан, мэдээ, өргөдөл гаргах заавар”-ыг 1 дүгээр хавсралтаар, даатгалын мэргэжлийн оролцогчийн мэдээг 2, 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, нийтэд мэдээлж сурталчлахыг Тамгын газар /Ж.Жадамбаа/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ДААТГАЛЫН КОМПАНИ БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧООС ТАЙЛАН, МЭДЭЭ, ӨРГӨДӨЛ ГАРГАХ ЗААВАР

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү зааврын зорилго нь Монгол Улсад ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж байгаа даатгалын компани (цаашид “даатгагч” гэх)-аас Даатгалын тухай хуулийн 14.2.13 дахь заалт, даатгалын мэргэжлийн оролцогч (цаашид “мэргэжлийн оролцогч” гэх)-оос Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 6.2.8 дахь заалтын дагуу тайлан, мэдээ, өргөдөл гаргахад мөрдлөг болгоход оршино.

1.2. Монгол Улсын Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, зааврын хүрээнд энэхүү заавар мөрдөгдөнө.

ХОЁР. Санхүүгийн тайлан

2.1. Санхүүгийн тайлан:

2.1.1. Даатгагч болон мэргэжлийн оролцогч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон даатгалын багц дүрэмд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана. Жилийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 68 дугаар тушаалаар баталсан “А” маягтаар, улирлын санхүүгийн тайланг “Б” маягтаар тус тус гаргана. Дөрөвдүгээр улирлын тайланг жилийн тайлантай нэгтгэж гаргана.

2.1.2. Санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд Хороонд гаргаж өгнө.

2.2. Санхүүгийн нэмэлт тайлан:

2.2.1. Даатгагч нь Хорооны 2007 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга хэлбэрийн заавар”-ын дагуу дараах санхүүгийн нэмэлт тайланг гаргана:

2.2.1.1. Орлогын тайлан;

2.2.1.2. Дүрмийн сангийн тайлан;

2.2.1.3. Даатгалын нөөц сангийн тайлан;

2.2.1.4. Даатгалын хураамжийн орлого, нөхөн олговрын тайлан;

2.2.1.5 Төлбөрийн чадварын тайлан;

2.2.1.6. Давхар даатгалын тайлан.

2.2.2. Даатгалын мэргэжлийн оролцогч нь Хорооны 2007 оны 192 дугаар тогтоолоор батлагдсан журмын дагуу орлогын тайлан гаргана.

2.2.3. Санхүүгийн нэмэлт тайлангуудыг улирал жилийн санхүүгийн тайлангийн хамт Хороонд ирүүлнэ.

2.2.4. Хороо хүлээн авсан санхүүгийн тайланг хянаж хариу өгнө.

ГУРАВ. Бусад тайлан

3.1. Аудитын тайлан. Даатгагч болон мэргэжлийн оролцогч нь Хорооноос эрх авсан аудиторыг томилж жилийн эцсийн санхүүгийн тайлангаа баталгаажуулж аудитын тайлан гаргуулан санхүүгийн тайлангийн хамт жил бүрийн 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор.

3.2. Актуарын тайлан. Даатгагч нь актуарын үйл ажиллагааны стандартын дагуу актуарын хяналт шалгалтыг хоёр жилд нэгээс доошгүй удаа хийж тайлан дүгнэлтийг шалгалт хийж дууссанаас хойш 30 хоногийн дотор Хороонд ирүүлнэ.

3.4. Статистик тайлан. Даатгагч нь Хорооны захиргааны мэдээллийн Д-2 маягтын дагуу даатгалын байгууллагын үйл ажиллагааны улирал, жилийн тайланг гаргаж 2, 5, 8, 11 дүгээр сарын 20-ны дотор тус тус Хороонд ирүүлнэ.

ДӨРӨВ. Мэдээ

4.1. Даатгагч нь төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн сар бүрийн мэдээг төлбөрийн чадварын тайлангийн маягтаар гаргаж дараа сарын 10-ны өдрийн дотор;

4.2. Даатгагч нь тухайн тайлант хугацаанд хамтран ажилласан мэргэжлийн оролцогчийн талаарх мэдээг энэ зааврын 2,3 дугаар хавсралтаар улирал жилийн тайлангийн хамт;

4.3 Даатгагч болон мэргэжлийн оролцогч нь тайлант жилд хяналт шалгалт хийсэн даатгалын аудитор, даатгалын актуарчийн талаарх мэдээг гаргаж жилийн тайлангийн хамт;

4.4. Даатгагчаас үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг бусдад шилжүүлэх болон нэгтгэх үед гарсан үйл ажиллагааны мэдээг хоёр тал хамтран үйлдэж тухай бүр;

4.5. Даатгагч болон мэргэжлийн оролцогч нь гадаад улсад салбар төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа явуулах, ердийн даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахтай холбоотой ирүүлсэн материалд нэр хаягийн өөрчлөлт, шилжилт хөдөлгөөн болон бусад өөрчлөлт орсон мэдээг тухай бүр гаргаж тус тус Хороонд ирүүлнэ.

ТАВ. Өргөдөл

5.1. Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчоос Хороонд дараах өргөдлийг гаргаж болно:

5.1.1. Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн тусгай зөвшөөрөл олгохыг хүсч;

5.1.2. Даатгалын хэлбэрээр тусгай зөвшөөрөл нэмж олгохыг хүсч;

5.1.3. Даатгалын компанийн салбар, төлөөлөгчийн газрыг байгуулж ажиллахыг хүсч;

5.1.4. Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг хүсч;

5.1.5. Даатгалын хэлбэрээр олгосон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг хүсч;

5.1.6. Даатгалын компанийн салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгаж, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгохыг хүсч;

5.1.7. Даатгагчаас үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг бусдад шилжүүлэх болон нэгтгэхийг хүсч;

5.1.8. Тусгай зөвшөөрөл авахтай холбоотой ирүүлсэн материалд өөрчлөлт оруулахыг хүссэн тухай бүр;

5.1.9. Бусад санал, гомдол, хүсэлт, мэдээлэл бүхий өргөдөл.

ЗУРГАА. Бусад зүйл

6.1. Хороо нь энэ журмын биелэлтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--

Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны
23 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

200 ... оны ...

сарын ... өдөр
(Даатгалын байгууллагын нэр)

ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН МЭДЭЭ
(Даатгалын хохирол үнэлэгч, даатгалын зуучлагчийн)

(төгрөгөөр)

Төрөл	Нэр	Хамтран ажилласан хугацаа /жил улирлаар/	Даатгагчид оруулсан орлого	Санхүүжилтийн эх үүсвэр /даатгагчаас/	Нэр хаягийн өөрчлөлт, шилжилт хөдөлгөөний тэмдэглэл
1	2	3	4	5	6
Даатгалын хохирол үнэлэгч					
Даатгалын зуучлагч					

Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны
23 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

200 ... оны ...

сарын ... өдөр
(Даатгалын байгууллагын нэр)

ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН МЭДЭЭ
(Даатгалын төлөөлөгчийн)

(төгрөгөөр)

Төрөл	Нэр	Хамтран ажилласан хугацаа /жил улирлаар/	Даатгагчид оруулсан орлого	Санхүүжилтийн эх үүсвэр /даатгагчаас/	Нэр хаягийн өөрчлөлт, шилжилт хөдөлгөөний тэмдэглэл
1	2	3	4	5	6
Даатгалын төлөөлөгч					

--ooOoo--